



Sonor Solo Festival 2026 - “French Impressions”

SONOR Сонгодог Хөгжмийн Сэдэвчилсэн Наадам 2026-т тавтай морилно уу! Энэ жилийн фестиваль нь Францын хөгжмийн тансаг өнгө аяс, өвөрмөц уур амьсгал, уран сэтгэмж, мөнхийн үнэ цэнийг хамтдаа нээх хөгжмийн аялалд оролцогчид, үзэгчдийг урьж байна. Фестивалийн хүрээнд Францын хөгжмийн зохиолчийн бүтээл, эсвэл гарчиг, агуулга, сэдэв нь Франц улс, түүний соёл, хэл, газар нутаг, урлагийн уламжлалыг илэрхийлсэн ямар ч гоцлол бүтээлээр оролцох боломжтой. Барокко үеийн сор бүтээлүүдээс эхлээд Импрессионизмын шилдэг бүтээлүүд, орчин үеийн хөгжмийн зохиолчдын туурвил хүртэл Францын хөгжмийн гоо үзэсгэлэн, өвөрмөц өнгө төрхийг хамтдаа мэдрэгчдээ.

SONOR Сонгодог Хөгжмийн Сэдэвчилсэн Наадам нь залуу хөгжимчдэд ур чадвар, уран бүтээлч чанараа тайзан дээр илэрхийлж, нөхөрсөг өрсөлдөөний орчинд өөртөө итгэх итгэлээ хөгжүүлэх боломжийг олгодог. Бид техникийн ур чадварыг уран сэтгэмж, хөгжмийн илэрхийлэл, тайзны соёлтой хослуулсан тоглолтыг өндрөөр үнэлдэг. Бидний зорилго нь зөвхөн ур чадварыг бус, хөгжимчин бүрийн давтагдашгүй хөгжмийн өнгө аяс, уран бүтээлчийн илэрхийлэл, хувь хүний онцлогийг хөгжимөөрөө чөлөөтэй илэрхийлэх боломжийг дэмжиж, түүнийг үнэлэн урамшуулахад оршино.

ЧУХАЛ ОГНОО:

Бүртгэл явагдах хугацаа:

8-р сарын 1-нээс 11-р сарын 1 хүртэл.

Бүртгэл дуусах өдөр:

11-р сарын 1.

Онлайн материалаа илгээх сүүлийн өдөр:

11-р сарын 1.

Эдгээр хугацаанаас хойш хүлээн авсан материалд \$25 хураамж ногдоно.

ONLINE FESTIVAL:

11-р сарын 8-ний Бямба гариг.

FESTIVAL болох өдөр:

11-р сарын 15-ны Бямба гариг. Berkeley, CA

Үр дүнг зарлах:

11-р сарын 22-ны Бямба гариг.

БҮРТГЭЛ: Биечлэн болон онлайн наадмын бүртгэл нээлттэй ба 2026 оны 11-р сарын 1-ны Бямба гаригт дуусна. Энд [дарж](#) бүртгэлийн маягт руу нэвтэрнэ үү. Бүртгэлийн маягтыг бөглөөд бүртгэлийн хураамж \$60 төлнө (буцаан олгогдохгүй)



Бүртгэлийн хураамж төлөх:

1. Zelle : 925-878-8763 утасны дугаарыг ашиглана уу

- Гүйлгээний утга: Оролцогчийн нэрийг бичнэ.

2. Чек : 2026 оны 11-р сарын 1-ний Баасан гариг хүртэл хүлээн авна.

- Шуудангийн хаяг: Sonor Music school 3391 Mt. Diablo Blvd. Suite B. Lafayette CA 94549
- Гүйлгээний утга : Оролцогчийн нэрийг бичнэ.

3. PayPal: Манай вэбсайт дээрх [PayPal](#) ашиглан төлбөр хийнэ.

- \$3.65 шимтгэл нэмэгдэх болно.

ФЕСТИВАЛЫН ДҮРЭМ:

- 5 - 18 насны, бvх тvвшиний оролцогчдод нээлттэй.
- Өөрийн сонгосон ангилалын өгөгдсөн хугацаанд тохирсон 1 зохиол тоглоно. D.C. al Fine-с бусад давталтыг тоглохгvй.
- Зохиолуудыг цээжээр тоглох шаардлагатай.
- Тvвшин тус бүрийн I, II, III байрны эздэд цом, гэрчилгээ болон шүүгчдийн үнэлгээ олгоно.
- Бvх оролцогчдод naadmiin гэрчилгээ, медаль болон шүүгчдийн үнэлгээ олгоно.

ОНЛАЙН: 2026 оны 11-р сарын 8-ний Бямба гариг.

- Бүртгэл 9-р сарын 1-нээс 11-р сарын 1-н хүртэл явагдана.
- **11-р сарын 1-ний** бүртгэлийн маягтаа бөглөж, \$60-ын бүртгэлийн хураамжаа төлөн, тоглолтын видеогоо, эх нотны PDF файлын хамт илгээнэ.
- Хугацаа хоцорсон бүртгэл, материалд \$25 хураамж ногдоно.
- Үр дүнг 2026 оны 11-р сарын 22-нд вебсайт болон сошиал платформоор зарлана.
- Онлайн оролцогчид сертификат болон шүүгчдийн үнэлгээгээ имэйлээр хүлээн авна.
- Шагналыг шуудангаар илгээнэ. Олон улсын тээвэрлэлтийн төлбөрийг хүлээн авагч өөрөө төлнө.



Видео бичлэг хийхэд тавигдах шаардлага:

- A. Видео бичлэгээ Youtube-д, жагсаалтаас гадуур байршуулж (unlisted), **Sonor Solo Festival 2026** гэж нэрлэнэ үү.
- B. Видео бичлэгийг тоглогчийн гар, нүүр, хөл бүтнээр харагдахаар нэг өнцгөөс (хажуу талаас) бичнэ. Засвар хийхийг зөвшөөрөхгүй.
- C. Видео бичлэгийн линкийг admin@sonormusicschool.com хаягаар илгээнэ үү.
- Имэйлийн гарчиг : SOLO Festival 2026, Оролцогчийн овог, нэр .
 - Имэйлийн үндсэн хэсэг: Хөгжмийн зохиолч, Бүтээлийн нэр, Ангилал (Түвшин).
 - Видео бичлэгийн линкийг Зохиолын нотны дижитал хэлбэрийн хамт хавсаргана. (нотны хавтасыг мөн хавсаргана)

БИЕЧЛЭН: 2026 оны 11-р сарын 15-ны Бямба гараг.

- Бүртгэл 9-р сарын 1-нээс 11-р сарын 1-н хүртэл явагдана.
- Тоглолтын тодорхой хуваарь жич гарна.
- Тэмцээний өдөр оролцогчид зохиолынхоо эх хувийг авчрах шаардлагатай.
- Шүүгчдийн шийдвэр эцсийнх бөгөөд өөрчлөгдөхгүй.
- Ангилал/түвшин болгоны тоглолтын дараа оролцогчид үр дүнгээ сонсоно.

АНГИЛАЛ / ТҮВШИН:

Ангилал A - Elementary	3 мин. хүртэл
Ангилал B - High Elementary	3 мин. хүртэл
Ангилал C - Intermediate	6 мин. хүртэл
Ангилал D - High Intermediate	6 мин. хүртэл
Ангилал E - Pre Advanced	8 мин. хүртэл
Ангилал F - Advanced	8 мин. хүртэл

Organized by



Ponovo music school